



Хорио цээрийн дэглэм гэж юу вэ?

Хорио цээрийн дэглэмийн үед КОВИД-19 халдварыг үүсгэгч SARS-CoV-2 вирус халдсан байж болох хүнийг бусдаас хол байлгадаг.



Би хорио цээрийн дэглэм хэр удаан сахих ёстой вэ?

ВАКЦИН ХИЙЛГЭЭГҮЙ

Ойрын хавьтал болсон бүх хүмүүс КОВИД-19-ийн шинжилгээ өгөх нь зүйтэй. Вакцин хийлгээгүй ихэнх хүмүүсийн хувьд хорио цээрийн дэглэм сахих хугацааг тодорхойлох хоёр арга байдаг. Хавьтсан өдрийг 0 өдөр гэж тооцохыг анхаарна уу.

1-р арга: Хэрэв та КОВИД-ийн шинжилгээ өгөөгүй бол халдвар авсны дараа 10 хоног гэртээ байх хэрэгтэй.

2-р арга: Та гэртээ 7 хоног байх хэрэгтэй бөгөөд хэрэв таны КОВИД-ийн шинжилгээний (шинжилгээг **5 дахь өдөр** эсвэл түүнээс хойших өдөр хийлгэх ёстой) хариу сөрөг гарвал 8 дахь өдөр дэглэмийг зогсоож болно. Хэрэв таны хариу эерэг байвал эсвэл танд КОВИД-ийн шинж тэмдэг илэрвэл та **нэн даруй** тусгаарлаж, тусгаарлах заавар авахын тулд эмч эсвэл нийгмийн эрүүл мэндийн газартай холбоо барих ёстой.

БҮРЭН ВАКЦИН ХИЙЛГЭСЭН

КОВИД-19-ийн сэжигтэй эсвэл батлагдсан хүнтэй ойр байсан вакцин хийлгэсэн хүмүүс дараах бүх шалгуурыг хангасан тохиолдолд хорио цээрийн дэглэм сахих шаардлагагүй.

- Таны вакцины эцсийн тунг хийснээс хойш дор хаяж 2 долоо хоног өнгөрчээ. Вакцины эцсийн тун гэж 2 тунтай цувралын (Pfizer, Moderna эсвэл ДЭМБ-аас зөвшөөрсөн Covishield эсвэл AstraZeneca гэх мэт вакцин) 2 дахь тун эсвэл нэг тунтай вакцины нэг тунг (Johnson & Johnson) хэлнэ.

БА

- Хамгийн сүүлд ойрын хавьтал болсноос хойш КОВИД-19-ийн шинж тэмдэг илрээгүй

Шинж тэмдэггүй байсан ч вакцин хийлгэсэн хүмүүсийг КОВИД-19-ийн тохиолдолтой ойр байснаас хойш 5-7 хоногийн дараа шинжилгээ өгөх нь зүйтэй.

Калифорни мужийн Нийгмийн эрүүл мэндийн газар ӨХУСТ-ийн удирдамжид үндэслэн КОВИД-19 хорио цээрийн шинэчилсэн удирдамжийг гаргасан бөгөөд <https://bit.ly/3hWbBPo> хаягаар үзэж болно.

Хорио цээрийн дэглэмийн тухай Аламеда каунтигийн Эрүүл мэндийн газрын захирлын тушаалыг <https://bit.ly/3kznDQk> хаягаар авах боломжтой.

Хорио цээрийн талаарх бүрэн зааварчилгааг энэ тусгаарлах/хорио цээрийн мэдээллийн багцаас үзнэ үү. <https://bit.ly/3hYz7vc>. Хэрэв та энэ холбоосыг ашиглах боломжгүй бол 510.268.2101 дугаарт залгаж, мэдээллийн багцыг шуудангаар танд илгээх боломжтой.



ALAMEDA COUNTY HEALTH CARE SERVICES AGENCY
PUBLIC HEALTH DEPARTMENT

Colleen Chawla – Agency Director
Kimi Watkins-Tartt – Director
Nicholas Moss, MD – Health Officer

Contact
Public Health Department:
(510) 267-8000 Main Line
COVID-19 Information:
(510) 268-2101

www.acphd.org

Ver: 9-14-2021